Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Иргэний болон захиргааны ШШГЭЗ-ийн тэнхимийн багш, дэслэгч

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ТӨЛБӨР ГАРГУУЛАХ НЬ

Монгол Улсад эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн томоохон ажлын нэг бол 2002 онд батлагдан гарсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль юм. Энэхүү салбарын хууль шинэчлэгдэн гарснаар олон зарчмын шинжтэй өөрчлөлтүүд гарсан. Нийгмийн харилцааны явцад шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хурцаар тавигдаж байгаа олон зүйлсийн нэг нь хуулийн этгээдтэй холбоотой шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа юм. Төлбөр төлөгч-хуулийн этгээдтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг "ХУУЛИЙН ЭТГЭЭД" гэдэг нь өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ тусгайлан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ.

Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хуульд буюу дүрэмд заасан зорилготой ашигийн төлөө бус байж болно. Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна. Хуульд өөрөөр заагаагүй бол хэд хэдэн хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болох бөгөөд нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадгална[188].

Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар гэдэг нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэж, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно. Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах журмыг хуулиар тогтооно. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хуульд заасан журмаар байгуулагдсанаар үүсэж, татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд бусад оролцогчтой адил тэгш эрхтэй оролцоно.

Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно. Хуулийн этгээдийн удирдах байгууллагын эрх зүйн байдлыг хууль буюу үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно. Ашгийн төлөө бус хуулийн этгээд өөрийн дүрэм болон үүсгэн байгуулсан бусад баримт бичигт заасан зорилгод нийцэх үйл ажиллагаа явуулна. Ашигийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй.

Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадварыг

---

[188] *Монгол Улсын Иргэний хууль. УБ., 2002 он, 25 дахь тал*

гагцхүү хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлана[189].

Хохирогч гэсэн ойлголтыг эрх зүйн салбар бүрт өөр өөр байдлаар тодорхойлсон байдаг. Жишээлбэл: Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд "Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ[190]" гэж тодорхойлжээ. Тэгвэл бидний үзэж буй иргэний хэргийн хохирогч ч мөн энэ талаараа хохирсон байдгаараа төсөөтэй юм.

Иргэн, хуулийн этгээд халдашгүй чөлөөтэй байх эрхтэй бөгөөд энэ тухай Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд "Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй гэж заажээ. Энэхүү заалтыг хэрэгжүүлэх нэг салбар бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй болно[191].

Өнөөгийн байдлаар төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах болон хуулийн этгээдтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалт бол

1. Иргэний хууль
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
3. Компаний тухай хууль
4. Улсын бүртгэлийн тухай хууль
5. Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх тухай хууль
6. Дампуурлын тухай хууль
7. Үнэт цаасны тухай хуулиудаар эрх зүйн харилцааг нь зохицуулж байна.

Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааг өнөөгийн түвшинд иргэний байгууллагуудаас лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт авах замаар явуулж байна. Төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа явуулах явцад гарч байдаг зүйлийн нэг нь тухайн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа тухайн хуулийн этгээдийн хөрөнгийг гэр бүлийн хөрөнгөөс ялгах ойлголт юм.

Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө ба компанийн хөрөнгийн зааг ялгаа

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад компанийн өр, төлбөрийг гэр бүлийн хувийн хөрөнгөөр хариуцах, гэр бүл салахад компанийн өмч хөрөнгийг хуваах эсэх гэсэн амьдралд үүсэх аль олон асуудал үүсдэг.

Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч хөрөнгөнд компанийн хөрөнгө хамаарах эсэх асуудал нь онол, практикийн хувьд маргаантай, хуулийн шууд зохицуулсан тодорхой заалт байхгүй, шүүхэд нэгдсэн практик тогтож чадаагүй учраас энэ асуудлыг тусгайлан судлах шаардлагатайн улмаас шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хүндрэлтэй байдал үүсдэг.

Аливаа улс гүрэн эдийн засаг дээр оршин тогтнож байдгийн адил гэр бүл өрхийн төсөв буюу өмч дээр суурилан амьдралаа залгуулж, амьжиргааны түвшингээ тодорхойлуулж байдаг байна.

Өмч гэдэг бол эрдэмтэн мэргэдийн тодорхойлсноор: "Эдийн баялгийг тодорхой этгээдэд хамааруулж, уг этгээдэд тухайн баялгийн хувьд олгогдсон хязгаргүй

---

[189] *Монгол Улсын Иргэний хууль. УБ., 2002 он, 26 дахь тал*

[190] *Бат-Эрдэнэ.Б. Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2004 он, 91 дэх тал*

[191] *Дашзэвэг.Б. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ. 2003 он. 13 дахь тал*

эрхийг бусад этгээд хүлээн зөвшөөрч байгаагаар илэрдэг нийгмийн харилцаа юм" гэжээ.

Өмчийн төрөл нь нийтийн болон хувийн өмчөөс бүрддэг бол хувийн өмч нь иргэний буюу дундын гэсэн хэлбэртэй байдаг ажээ.

Гэр бүл айл өрхийн бүхий л өмч хөрөнгийг хувьд ноогдох хөрөнгө, хамтран өмчлөх дундын өмчлөлийн хөрөнгө гэж үндсэн хоёр хэсэгт хуваадаг ажээ

Нэгдүгээрт:

Хувьд ногдох хөрөнгө гэдэгт: эхнэр, нөхөр, хүүхдийн хуваарьт өмч хамаардаг ба энэ нь анх гэр бүл болохдоо өөрсдийн авчирсан эд хогшил байхаас гадна гэр бүл болоход нь бэлэг болгон өгсөн, эсхүл амьдрах явцад бий болгосон эд зүйлийн хэрэглээний шинжээс шууд хамаарч хуваарьт өмчид хамаардаг байна.

Жишээлбэл, байшин, гэр, зурагт, хөргөгч бэлэглэх буюу худалдан авбал дундаа хэрэглэх утгаараа хамтран өмчлөх дундын хөрөнгө болдог бол, ээмэг, цүнх, үсний хавчаар бэлэглэх буюу худалдан авбал эхнэрийн, сахалын машин, зангиа, костьюм пиджак бэлэглэх буюу худалдан авбал нөхрийн, жихэвч, хүүхдийн тоглоом, хичээлийн хэрэгсэл зэрэг нь тухайн хүүхдийн хуваарьт өмч болно.

Хоёрдугаарт:

Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч хөрөнгө гэдэгт:

Гэрлэх үедээ, гэрлэснээс хойш хамтын хөдөлмөр, аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого, мөнгөн хуримтлал, шинээр бий болсон хөрөнгө "үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө", ногдол хувь, үнэт цаас, гэр бүлийн гишүүний хэн нэгний нэр дээр байгаагаас үл шалтгаалан гэрлэснээс хойш бий болсон бусад хөрөнгө, гэр бүлийн гишүүн өөрийн хуваарьт хөрөнгөөс дундаа хамтран өмчлөхөд зориулж шилжүүлсэн хөрөнгө, мөнгөн хуримтлал, анх гэр бүл болоход нь зориулагдсан /орон сууц, гэр, хашаа, байшин зэрэг/ бол хамтын өмч болно.

Хуваарьт өмчийг үндэслэлтэй зөв тогтоосноор, хамтран өмчлөх дундын өмч хөрөнгийг шударга тогтоох үндэслэл болдог байна. Ийнхүү тогтоогдсон хөрөнгөнд компанийн хөрөнгө хамаарах эсэх асуудал гэр бүлийн өмчийн маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Яг энэ цэгээс компанийн өмч гэсэн шинэлэг ойлголт урган гарч байгаа юм.

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Компанийн балансанд тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн нийт дүнгээс компанийн өр төлбөрийг хасаж үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлэгчдийн хөрөнгө гэнэ" гэж тодорхойлжээ. Үүнээс авч үзвэл

Компанийн өмч гэдэг ойлголтонд: аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан блансанд нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу тусгагдсан, бодитойгоор нэр зааж оруулсан эд зүйлс, эд хөрөнгийн эрхээр цогцлон бүрдсэн хөрөнгийн нийт дүнгээс бусдад төлөх ёстой өр зээлийг хасаад цэвэр үлдэгдэл хөрөнгө нь хувь нийлүүлэгчдийн буюу компанийн өөрийн хөрөнгөнд ордог байна.

Аливаа компани нь өөрийн гэсэн дүрэмтэй, дүрмийн сантай, санхүү бүртгэл, тайлан тооцоотой, ашиг, алдагдлаа тооцдог, хувьцаа, үнэт цаастай, хөрөнгийг захиран зарцуулах эрх хэмжээг урьдчилан тогтоосон, зарцуулчихаад дараа нь тайлагнадаг байна.